

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04 сарын 20 -ны өдөр

Дугаар 18/02

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 15:00 цагт эхлэв.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хурлын ирцийн талаарх мэдээг Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийг танилцуулна уу гэж индэрт урья.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийг танилцуулснаар:

Тооллогын комиссын шийдвэр: “1,019,816,252 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй буюу 435 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрхтэй хувьцаа бүхий 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны 95,94 хувийг төлөөлсөн хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн” байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дэх заалт, Компанийн Дүрмийн 7-р зүйлийн 7.11-д заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын агуулгыг танилцуулав.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг, Санхүү эрхэлсэн захирал Б.Түвшин, ТУЗ-ийн Хараат бус гишүүн Ж.Үнэнбат нарыг тайзнаа урилаа.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга хэлэлцэх асуудлыг танилцуулах

- I. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - II. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт /хүн тус бүр 3 мин/
 3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах /5 мин/
 4. Санал хураалт явуулах /20 мин/
 5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /40 мин/
 6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах /5 мин/
 7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /5 мин/
 8. Хурлыг хаах

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. [Тайланг хавсаргав]

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Номин: Надад 2 асуулт байна.

1. Монгол залуучууд 1000 долларын төлөө Солонгос явж байна. АПУ-ийн залуучуудын цалин хэзээ 1000 доллар болох боломжтой вэ?
2. Болор 28 градустай архины борлуулалтын талаар мэдээлэл өгнө үү?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. Монгол хүний үнэ цэнийг өсгөх асуудал бол маш чухал асуудал юм. Өнөөдрийн байдлаар АПУ-ийн ажилтнуудын дундаж цалин 1,600,000 төгрөг бөгөөд манай хамт олон 1000 долларын төлөө зүтгэх болно. Жил бүр цалинг оновчтой авч үзэх бөгөөд дараа жил гэхэд энэ хэмжээнд хүргэнэ гэж амлаж чадахгүй. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал хууль эрх зүйн тогтворгүй байдал, татварын хувь хэмжээний өсөлт, эдийн засгийн орчин, компанийн засаглал, зөв төлөвлөлт юм. Компанийн бүтээмжийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн зөв бүтцийг бий

болгож, цалинг зорилтот хэмжээнд хүргэнэ. Гэхдээ өнөө маргааш гэхэд нэмж чадахгүй ч ойрын хэдэн жилдээ хийхийг зорино.

2. 28 градустай Болор архины хувьд бага градустай архины хэрэглээ хараахан хэрэглэгчдэд хэвшээгүй байна. Цаашдаа өөрчлөгдөх болов уу гэж бодож байна. Ялангуяа шинэ үе алкоголь багатай зөөлөн хэрэглээ рүү шилжих байх, гэхдээ энэ шилжилт 5 жилийн дараа мэдрэгдэхээр байна гэж харж байна.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Ганбаатар: Жилийн тайлангийн 68 хуудас дахь “хөрөнгө” дээр гүүдвил 217 гэснийг тайлбарлаж өгнө үү?

Хариулт:

Санхүү эрхэлсэн захирал Б.Түвшин: Энэ бол мэргэжлийн ойлголт бөгөөд 9 компани нэгдээд хувьцаат компанид нэгтгэгдэж, нэгтгэсэн баланс гарсан. Энэхүү баланст 9 компанийн хөрөнгө оруулалт, цэвэр хөрөнгийн үнийн зөрүүг гүүдвил гэж бүртгэдэг. Өөрөөр хэлбэл бид компаниудыг худалдаж авсан үнэ, тэдний хөрөнгийн цэвэр үнэ хоёрын зөрүү гэж ойлгож болно.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч: Хөрөнгийн үнэлгээ болон бизнесийн үнэлгээг хөндлөнгийн компаниар хийлгэж байгаа гэсэн? Энэ нь эздийн өмчийг хэр хэмжээнд өсгөх боломжтой вэ?

Хариулт:

Санхүү эрхэлсэн захирал Б.Түвшин: 2 төрлийн үнэлгээ хийгдэж байгаа. Бизнесийн үнэлгээ талаас сая ярьсан цэвэр хөрөнгийн үнэлгээ хийгдэхэд гүүдвиллийн үнэлгээ өөрчлөгдөнө гэсэн үг. Нөгөө талаас хөрөнгө нэг бүрчлэн үнэлэгдэж баланс дахь нийт дүн өөрчлөгдөнө. Хөрөнгийн үнэлгээг PwC гэсэн дэлхийд алдартай компанийн Казакстан дахь салбар хийж ажиллаж байна. Одоо манай баланс дээр байгаа 600 гаруй тэрбум төгрөг бол үнэлгээ хийгдээгүй дүнгээрх механик нийлбэр бөгөөд хөрөнгийн үнэлгээ хийгдээд, гүүдвиллийн үнэлгээ хийгдсэн тайлан гарч, KPMG аудитаар баталгаажигдаж энэ оны 05 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулахад бэлэн болох юм.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч: Бага хувьцаа эзэмшигчид 5,9%-ийг бүрдүүлж байгаа хүмүүс энд цугларсан байх гэж бодож байна. Манайхан ер нь эвлэлдэн нэгдэхдээ муу хүмүүс санагддаг. Хэрвээ үл ойлголцол гараад эргээд салан тусгаарлахад хүрвэл бага хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан тал дээр эрсдэлээ тооцож үзсэн болов уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Энэ нэгдэл өөрөө бага хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн нэгдэл болсон. Бага хувьцаа эзэмшигчдийн хамгийн төлөөлөл бол

Хайнекен компани буюу 25%-ийн хувьцаа эзэмшигч. Энэ бол өнөөдрийн компанийн менежмент, багт хяналт тавих, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад зохистой дэмжлэг үзүүлэх тал дээр ач холбогдолтой. Нөгөө талаас Голомт банк маань 13%-ийн хувьцаа эзэмшигч, бас л бага хувьцаа эзэмшигч юм.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Нармандах: 2 асуулт байна.

1. Хайнекен хувьцаа эзэмшигчээр орж ирснээс хойш компанийн гүйцэтгэх удирдлага, менежментийн багт тэднээс томилогдсон удирдлага байгаа юу? Ямар хяналт тавьдаг вэ? Менежментийн багтай яаж харилцдаг вэ?
2. Экспортын ажилд Хайнекен ямар туслалцаа үзүүлж байгаа, ямар төлөвлөгөөтэй байгаа вэ?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. Хайнекен компани ТУЗ-д 2 гишүүний төлөөлөлтэй буюу ТУЗ-ийн шийдвэрт онцгой нөлөө бүхий юм. Заавал Хайнекенаас менежментийн багт хэдэн хүн байх ёстой гэсэн заалт байхгүй. Гэхдээ бид нарын ашиг сонирхол бол Хайнекенаас чадварлаг туршлагатай хүмүүсийг авч ажиллуулах хүсэлтэй. Өнөөдөр манай Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал Daniel гэж хүн байгаа, тэрээр Хайнекенаас томилогдож ирсэн. Түүнчлэн шар айрагны үйлдвэрт Paul гэж мэргэжилтэн ажиллаж байна. Эдгээр хүмүүсийг компанийн хөгжилд хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна. Цаашдаа ч мэргэжлийн багийг ажиллуулахыг боддог.
2. Экспортын хувьд Хайнекенийг тус хүргэнэ гэж хардаг. Хайнекен бол шар айраг үйлдвэрлэгч, харин бид архин бүтээгдэхүүнийг экспортлох илүү сонирхолтой ба түүний сүлжээ, танилыг ашиглаж экспортлохоор төлөвлөдөг.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Өөр асуулт байна уу?

Асуулт байсангүй.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Энэ жилийн аудитыг KPMG аудит хийж гүйцэтгэж байгаа бөгөөд нэгдлийн ажлын хүрээнд маш их өөрчлөлт орсноос шалтгаалж аудитын дүгнэлт хуулийн хугацаандаа гарч амжихгүй бөгөөд KPMG аудитын тайлан 2018.05.31-ний өдрөөр танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Иймд ТУЗ хараахан аудитын тайланг хүлээж аваагүй байгаа ч өөрийн зүгээс дүгнэлтийг гаргасан ба Гүйцэтгэх захирал болон менежментийн багийн компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ болон

хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлсэн гэж дүгнэж байна. Энэхүү дүгнэлтийг хэлэлцэж батлуулахаар санал оруулж байна.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болсон үндэслэл нь:

- Компанийн Дүрэмд одоо үйлчлэхээ больсон зохицуулалт байгааг нийцүүлэх шаардлага гарч ирсэн;
- Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн жагсаалтаас тусгай зөвшөөрөл байхгүй үйл ажиллагааг хасч, бодитойгоор хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны жагсаалтыг шинэчлэн гаргах шаардлагыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс шаардсан;
- Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит бус хурлын 18/01 тоот тогтоолын дагуу Компанийн эрх мэдлийн хуваарилалтын баримт бичгийг батлах, мөрдүүлэх эрхийг ТУЗ-д олгосон ба уг шийдвэрийг хэрэгжүүлж, ТУЗ-ийн хурлын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 18/09 тоот тогтоолоор “Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичиг” батлагдсан. Уг эрх мэдлийн хуваарилалтаар компанийн нэгдлийн оролцогч компаниудын удирдлагын бүрэн эрх, эрх хэмжээний хязгаарыг тогтоосон ба үүнд нийцүүлэн Дүрмийн холбогдох заалтыг өөрчлөх хэрэгтэй шаардлага үүссэн;
- Компанийн шинэ бүтэц, зохион байгуулалтын дагуу “эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг өөрчлөн нийцүүлэх шаардлага бий болсон.

Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах төслийн агуулга:

2-р зүйлийн 2.1 дэх хэсэгт “Хэрэглэгчийн сэтгэлд тохирсон, хүнсний аюулгүй байдлыг хангасан хамгийн сайн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэж ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.” гэж заасныг хасах;

2-р зүйлийн 2.2 дах хэсгийг доорх байдлаар өөрчлөх; “2.2 Компанийн үйл ажиллагааны чиглэл нь дараах байна:

- 2.2.1. Архины үйлдвэрлэл;
- 2.2.2. Шар айрагны үйлдвэрлэл;
- 2.2.3. Спиртийн үйлдвэрлэл;
- 2.2.4. Ундаа, ус, жүүсны үйлдвэрлэл;
- 2.2.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- 2.2.6. Бөөний болон жижиглэн худалдаа;
- 2.2.7. Гадаад худалдаа;

2.2.8. Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах үйл ажиллагаа;

2.2.9. Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;

2.2.10. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

7-р зүйлийн 7.22.17 (ТУЗ-ийн бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.22.17. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, эрх олгох;

7-р зүйлийн 7.37 (Гүйцэтгэх захирлын бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.37. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлүүлэх асуудлын төслийг боловсруулж шийдвэрлүүлэх, зөвшөөрөл авах;

7-р зүйлийн 7.35 (Гүйцэтгэх захирал) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.35. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж болно. Харин компанийн охин болон хараат компаниас бусад өөр аж ахуйн нэгж, өрсөлдөгч хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.

8-р зүйлийн 8.1 (Компанийн эрх бүхий албан тушаалтан) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

1.1. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Чиглэл хариуцсан захирлууд нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлт орсноос бусад зүйл заалтууд хэвээр үлдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийг тусгасан Дүрмийг хавсралтаас баталж, түүнийг улсын бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөнө.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу?

Асуулт байсангүй.

Санал хураалт явагдав.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэг: Санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1,019,816,252 ширхэг хувьцаа эзэмшиж буй 435 хувьцаа эзэмшигчид хуралд оролцсон. Үүнээс 1,019,377,339 ширхэг хувьцаатай 365 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлснээс 1,019,058,526 ширхэг хувьцаа эзэмшиж буй 306 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүчин төгөлдөр, үлдэх 318,813 ширхэг хувьцаатай 59 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүчингүй байв.

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 1,019,009,297 ширхэг хувьцаа буюу 99.9952%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 6,661 ширхэг хувьцаа буюу 0.0007%,

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 42,568 ширхэг хувьцаа буюу 0.0042%.

2. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 1,019,002,857 ширхэг хувьцаа буюу 99.99454%,

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 200 ширхэг хувьцаа буюу 0.00002%,

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 55,469 ширхэг хувьцаа буюу 0.00544%.

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

2. АПУ ХК-ийн Дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулсугай.

2-р зүйлийн 2.1 дэх хэсэгт “Хэрэглэгчийн сэтгэлд тохирсон, хүнсний аюулгүй байдлыг хангасан хамгийн сайн чанартай бүтээгдэхүүн

үйлдвэрлэж, худалдах замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэж ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.” гэж заасныг хасах;

2-р зүйлийн 2.2 дах хэсгийг доорх байдлаар өөрчлөх; “2.1 Компанийн үйл ажиллагааны чиглэл нь дараах байна:

- 2.1.1. Архины үйлдвэрлэл;
- 2.1.2. Шар айрагны үйлдвэрлэл;
- 2.1.3. Спиртийн үйлдвэрлэл;
- 2.1.4. Ундаа, ус, жүүсны үйлдвэрлэл;
- 2.1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
- 2.1.6. Бөөний болон жижиглэн худалдаа;
- 2.1.7. Гадаад худалдаа;
- 2.1.8. Хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах үйл ажиллагаа;
- 2.1.9. Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
- 2.1.10. Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

7-р зүйлийн 7.22.17 (ТУЗ-ийн бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.22.18. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, зөвшөөрөл олгох, эрх олгох;

7-р зүйлийн 7.37 (Гүйцэтгэх захирлын бүрэн эрх) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.38. Эрх мэдлийн хуваарилалтын баримт бичигт заагдсан эрх мэдлийн хэмжээ хязгаарын хүрээнд асуудлыг шийдвэрлэх, эрх олгох, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсны үндсэн дээр шийдвэрлүүлэх асуудлын төслийг боловсруулж шийдвэрлүүлэх, зөвшөөрөл авах;

7-р зүйлийн 7.35 (Гүйцэтгэх захирал) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

7.35. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж болно. Харин компанийн охин болон хараат компаниас бусад өөр аж ахуйн нэгж, өрсөлдөгч хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.

8-р зүйлийн 8.1 (Компанийн эрх бүхий албан тушаалтан) хэсгийг доорх байдлаар өөрчлөн найруулах;

8.1. ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Чиглэл хариуцсан захирлууд нь компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.

3. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлт орсноос бусад зүйл заалтууд хэвээр үлдэх бөгөөд нэмэлт өөрчлөлтийг тусгасан Дүрмийг хавсралтаас баталж, түүнийг улсын бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөнө.
4. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

Ээлжит хурлыг хаав.

Хурал 17 цаг 25 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:


Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг